



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/37/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ч.Наранбадрах
Утас: 70533552 Цахим хаяг: Naranbadrakhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|------------------------------|
| Аудитын гол асуудал..... | Error! Bookmark not defined. |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН..... | 3 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 5 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 7 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 7 |
| 4.2 Материаллаг байдал..... | 7 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 7 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 7 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 7 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 8 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 8 |
| Тайлант оны үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно..... | 8 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 8 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... | 8 |
| 5.2 Албан шаардлага..... | 8 |
| 5.3 Зөвлөмж..... | 8 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 10 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>8,513,315.95</u> | <u>1,354,301.22</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ 6,466,035.88 | 60,529.35 | |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 425.50 | 425.50 |
| 31110 | Төгрөг | 425.50 | 425.50 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 6,465,610.38 | 60,103.85 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 12,931,220.76 | 120,207.70 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,047,280.07 | 1,293,771.87 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,091,320.07 | 1,181,731.87 |
| 354 | Хангамжийн материал | 955,960.00 | 112,040.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 44,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 955,960.00 | 68,040.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>52,266,420.41</u> | <u>46,118,584.25</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 52,266,420.41 | 46,118,584.25 |
| 391 | Газар | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 392 | Биет хөрөнгө | 49,783,060.40 | 43,910,224.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 53,519,471.53 | 53,019,471.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (10,005,164.65) | (13,337,997.61) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 4,800,000.00 | 4,750,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (876,663.33) | (2,586,666.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 2,730,000.00 | 2,730,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (384,583.15) | (664,583.15) |
| 393 | Биет бус хөрөнгө | 683,360.01 | 408,360.06 |
| 39301 | Програм хангамж | 1,905,000.00 | 660,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,221,639.99) | (251,639.94) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>60,779,736.36</u> | <u>47,472,885.47</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>15,374,481.20</u> | <u>9,082,883.87</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15,374,481.20 | 9,082,883.87 |
| 4136 | Бусад өглөг | 11,639,481.20 | 9,082,883.87 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 194,454.53 | - |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 11,445,026.67 | 9,082,883.87 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 3,735,000.00 | - |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 3,735,000.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>45,405,255.16</u> | <u>38,390,001.60</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 45,405,255.16 | 38,390,001.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 19,256,833.00 | 19,256,833.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 17,456,833.00 | 17,456,833.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (12,102,490.30) | (19,117,743.86) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (12,102,490.30) | (12,102,490.30) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (7,015,253.56) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 38,250,912.46 | 38,250,912.46 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>60,779,736.36</u> | <u>47,472,885.47</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1) | 12,976,418.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,976,418.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,976,418.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,595,902.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,595,902.80 |
| 120009 | Бусад орлого | 50,000.00 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 10,330,516.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 19,991,669.03 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 19,991,669.03 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 19,991,669.03 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,189.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,189.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,410,829.30 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 751,520.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 8,659,309.30 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,710,960.43 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,362,142.83 |
| 210807 | Газрын төлбөр | 664.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 34,000.00 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 4,314,153.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,868,690.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,000.01 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,835,690.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (7,015,250.23) |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (3.33) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (7,015,253.56) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 6,858,596.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,858,596.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,858,596.00 |
| 120009 | Бусад орлого | 279,980.00 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 6,578,616.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 13,281,002.53 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 13,281,002.53 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 13,281,002.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,728,508.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 2,728,508.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 792,960.00 |

| | | |
|-------------|---|------------------------------|
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 792,960.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 752,709.29 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 752,709.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,938,801.10 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 7,938,801.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,068,024.14 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 674,024.14 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 394,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>(6,422,406.53)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (6,422,406.53) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,466,035.88 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 60,529.35 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------|--------------|---|
| 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -12,102,490.30 | 1,800,000.00 | 45,405,255.16 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -12,102,490.30 | 1,800,000.00 | 45,405,255.16 |
| 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -12,102,490.30 | 1,800,000.00 | 45,405,255.16 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -12,102,490.30 | 1,800,000.00 | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 0.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -12,102,490.30 | 1,800,000.00 | 45,405,255.16 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,015,253.56 | 00.00 | -7,015,253.56 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 17,456,833.00 | 38,250,912.46 | -19,117,743.86 | 1,800,000.00 | 38,390,001.60 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр стандартын шаардлага хангасан орчинд орон нутгийн иргэд болон эрүүл мэндийн байгууллагад үйлчилдэг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуй нэгжид мөрдөх санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|-----------------|-----------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 2,047.2 | 1,293.7 | -753.5 |
| Үндсэн хөрөнгө | 52,266.4 | 46,118.5 | -4,147.8 |
| Нийт хөрөнгө | 60,779.7 | 47,472.8 | -6,291.5 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 45,45.2 | 38,390.0 | -7,015.2 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 6,779.7 | 47,472.8 | -13,36.8 |

Дээрх хүснэгтээс харахад Цито говь ОНӨААТҮГ нь өр авлага үүсгээгүй байна, үндсэн хөрөнгө 4.1 сая төгрөгөөр буурсан, бараа материал 0.7 сая төгрөгөөр буурсан нь эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэл буурснаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын -ын техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Наранбадрах гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Ханхонгор сумын Цитоговь ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБӨУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 0.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2- 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБӨУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 2023 оны төсвийн төслийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь "Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус онд төсвийн хөрөнгийн захиран зарцуулсан тушаал шийдвэр холбогдох хууль тогтоомжийг эрх зүйн чадамжийг хангасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.0 сая төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс, 3 зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Е баримтын зардлыг барааны нэр, төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог" дахь заалттай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах.

2. Илрүүлэлт: Бүтэц орон тоо үндсэн цалин батлахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийг баримталж ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

3. Илрүүлэлт Шилэн дансны цахим системд 2023 оны төсвийн төслийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" дахь заалттай нийцэхгүй байна Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхий

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------------------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлого үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэл тайланд татагдаагүй байна. | 1 | 0 | | | | | 1 | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----|------------------------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бүтэц орон тоо үндсэн цалин батлахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийг баримталж ажилласан байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 2 | 0 | | | | | 2 | 0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | | |
|--------------------|-------------|-----|------------------------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | |
|--|---|---|--|--|---|---|--|--|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд 2023 оны төсвийн төслийг байршуулаагүй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |